



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ

2018 оны 12 сарын 11 өдөр

Дугаар 542

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгө балансаас балансад
шилжүүлэх тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 30 дугаар зүйлийн 2, 31 дүгээр зүйлийн 1, 2, 3 дахь хэсэг, "Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам"-ын 5.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1.Баянгол, Хан-Уул, Сонгинохайрхан дүүргийн эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн Тамгын газрын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй нийт 21,000,000.00 (хорин нэгэн сая) төгрөгийн балансын үнэ, 13,300,000.00 (арван гурван сая гурван зуун мянган) төгрөгийн хуримтлагдсан элэгдэл бүхий хавсралтад заасан автомашиныг Говь-Алтай аймгийн шүүхийн Тамгын газарт балансаас балансад шилжүүлсүгэй.

2.Баянгол, Хан-Уул, Сонгинохайрхан дүүргийн эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн Тамгын газрын дарга Н.Чулуунжав, Говь-Алтай аймгийн шүүхийн Тамгын газрын дарга Ж.Ганболд нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:


2.1.Байгууллагын өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор үндсэн хөрөнгийг шилжүүлэх ажлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулах;

2.2.Хөрөнгийн хөдлөлийг зохих журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, "Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем"-д бүртгэх;

2.3.Энэ тогтоолын биелэлтийг 2019 оны 1 дүгээр улиралд багтаан Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт ирүүлэх.


3.Энэхүү тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, хяналтын хэлтэс (Ц.Түвшинзаяа)-т даалгасугай.

ДАРГЫН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ

 Б.ГАНБАТ

ЗАХИРГАА, ХУУЛЬ ЗҮЙН
ХЭЛТСИЙН ДАРГА

 Б.ГАВАА



Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2018 оны 12 дугаар сарын 11-ны өдрийн
672 дугаар тогтоолын хавсралт

БАЛАНСААС БАЛАНСАД ШИЛЖҮҮЛЭХ АВТОМАШИН

Д/д	Хөрөнгө шилжүүлэн өгөх байгууллага	Хөрөнгийн нэр, Улсын дугаар, Арлын дугаар	Үйлдвэрлэсэн он	Ашиглалтад орсон он	Нийт гүйлт /км/	Балансын үнэ	Хуримтлагдсан элэгдэл	Үлдэх өртөг	Шилжүүлэн авах байгууллага
(төгрөг)									
1	Баянгол, Хан-Уул, Сонгинохайрхан дүүргийн эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн тамгын газар	Pick up L200 машин, 62-84 УБУ, MMBJNK7403D043616	2005	2014	147330	21,000,000	13,300,000	7,700,000.00	Говь-Алтай аймаг дахь шүүхийн тамгын газар
НИЙТ ДҮН									
						21,000,000	13,300,000	7,700,000	
						(хөрөн нэгэн сая)	(арван гурван сая гурван зуун мянган)	(долоон сая долоон зуун мянган)	